

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар баталгаат байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомж

2.1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зарчим

3.1.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

3.1.1.хууль дээдлэх;

3.1.2.хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангасан байх;

3.1.3.сонирхогч талуудын оролцоог тэгш хангасан байх;

3.1.4.баримт нотолгоо, шинжлэх ухаан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан байх;

3.1.5.бие даасан, хараат бус байх;

3.1.6.ил тод, нээлттэй байх;

3.1.7.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

3.1.8.иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, худалдаанд хуульд заасан үндэслэл, журмаас гадуур аливаа хэлбэрээр саад учруулахгүй байх.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."стандарт" гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж, эрх бүхий байгууллагаас баталсан баримт бичгийг;

4.1.2.“стандартчилал” гэж бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг;

4.1.3.“техникийн зохицуулалт” гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, түүнтэй холбоотой боловсруулалт болон үйлдвэрлэлийн аргууд, түүний дотор заавал биелүүлэх заалтыг тогтоосон баримт бичгийг;

4.1.4.“тохирлын үнэлгээ” гэж бүтээгдэхүүн, үйл явц, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалт, тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг;

4.1.5."тохирлын үнэлгээний байгууллага" гэж энэ хуулийн 4.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий байгууллагыг;

4.1.6.“тохирлын гэрчилгээ” гэж бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалт, тогтоосон шаардлагад нийцэж байгааг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.7.“тохирлын үнэлгээний итгэмжлэл” гэж эрх бүхий байгууллагаас тохирлын үнэлгээний үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн чадавхтайг тогтоох ажиллагааг;

4.1.8.“тохирлын тэмдэг” гэж бүтээгдэхүүн нь стандарт, тогтоосон шаардлагыг хангаж байгааг тодорхойлсон тэмдэглэгээг;

4.1.9.“аюулгүйн тэмдэг” гэж бүтээгдэхүүн нь техникийн зохицуулалтаар тогтоосон шаардлагыг хангаж байгааг тодорхойлсон тэмдэглэгээг;

4.1.10.”нийлүүлэгчийн мэдэгдэл” гэж бүтээгдэхүүн, үйлчилгээ нь стандарт, техникийн зохицуулалт, тогтоосон шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс бичгээр гаргасан нотолгоог;

4.1.11.“бүтээгдэхүүн” гэж үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцад бий болсон үр дүнг;

4.1.12.“стандартчиллын техникийн хороо” гэж стандартчиллын тодорхой чиглэлээр үндэсний, олон улс болон бүс нутгийн стандартыг боловсруулах, хөгжүүлэх, хянан магадлах үүрэг бүхий ажлын хэсгийг;

4.1.13.“стандарт боловсруулах үйл ажиллагааны үндсэн баримт бичиг” гэж стандартчиллын үйл ажиллагаанд баримтлах техник ажлын журам болон стандартын бүтэц, бичвэр, боловсруулах дүрмийг тогтоосон үндэсний стандартыг;

4.1.14.“лаборатори” гэж сорилт, шинжилгээ, хэмжилт, шалгалт тохируулга болон бусад техникийн үйл ажиллагаа явуулах зориулалттай, тоног төхөөрөмж, арга зүй, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байгууллагыг.

4.2.Энэ хуулийн 4.1-д зааснаас бусад нэр томъёог Монгол Улсын хууль, олон улсын стандартчиллын байгууллагаас баталсан стандарт, удирдамж, Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрт заасны дагуу ойлгож хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ СТАНДАРТЧИЛАЛ

5 дугаар зүйл.Стандартчиллын зорилго, баримт бичиг

5.1.Стандартчиллын зорилго нь бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал болон сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

5.2.Стандартчиллын баримт бичигт дараах баримт хамаарна:

5.2.1.Монгол Улсын үндэсний стандарт /цаашид “үндэсний стандарт” гэх/;

5.2.2.байгууллагын стандарт;

5.2.3.олон улс, бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, гадаад улсын стандарт.

5.3.Стандартчиллын баримт бичиг зохиогчийн эрхэд хамаарахгүй.

6 дугаар зүйл.Үндэсний стандарт

6.1.Үндэсний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

6.2.Үндэсний стандартын үзүүлэлт, шаардлага нь олон улс, бүс нутгийн стандартын шаардлагад нийцсэн байна.

6.3.Үндэсний стандартын төслийг сонирхогч талууд зөвшилцлийн үндсэн дээр санаачлан боловсруулна.

6.4.Үндэсний стандарт нь товчилсон тэмдэглэгээ, улсын бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол стандартчиллын баримт бичгийн мэдээллийн санд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.5.Үндэсний стандарт нь энэ хуулийн 31-д заасан мэдээллийн нэгдсэн санд нээлттэй үнэ төлбөргүй байна.

7 дугаар зүйл.Байгууллагын стандарт

7.1.Хуулийн этгээд байгууллагын стандартыг боловсруулан баталж, үйл ажиллагаандаа хэрэглэж болно.

7.2.Байгууллагын стандарт нь олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.

7.3.Байгууллагын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний харьяа аймаг, нийслэл дэх байгууллагад бүртгүүлнэ.

7.4.Үндэсний стандарт шинээр болон шинэчлэн батлагдсан тохиолдолд хуулийн этгээд байгууллагынхаа стандартыг үндэсний шинэ стандартад нийцүүлэн бүртгүүлнэ.

8 дугаар зүйл.Олон улс, бүс нутгийн стандарт, гадаад улсын стандарт

8.1.Иргэн, хуулийн этгээд нь олон улс, бүс нутгийн стандарт, удирдамж, зөвлөмж, гадаад улсын стандартын монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэж болно.

8.2.Хүчин төгөлдөр бус, эсхүл хууль тогтоомж, техникийн зохицуулалт, үндэсний стандарт болон Монгол Улсын олон улсын гэрээ, олон улс, бүс нутгийн стандартаар тогтоосон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах шаардлагыг бууруулсан стандартыг иргэн, хуулийн этгээд хэрэглэхгүй.

8.3. Иргэн, хуулийн этгээд нь бүртгүүлэн хэрэглэж байгаа стандартыг 18 сарын дотор үндэсний стандартаар батлуулна.

8.4.Бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортлох зорилгоор бүртгүүлэн хэрэглэж байгаа стандарт энэ хуулийн 8.3-т хамаарахгүй.

9 дүгээр зүйл.Стандартчиллын техникийн хороо

9.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд салбарын харьяаллаар үндэсний болон олон улс, бүс

нутгийн, стандартын төслийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус Стандартчиллын техникийн хороо /цаашид “Техникийн хороо” гэх/ ажиллана.

9.2.Техникийн хороо нь төрийн байгууллага, тухайн салбарын мэргэжлийн холбоо, хуулийн этгээд, шинжлэх ухааны байгууллагын төлөөлөл болон сонирхогч талуудын төлөөлөл бүхий гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

9.3.Техникийн хороо дараах эрх, үүрэгтэй:

9.3.1.үндэсний стандарт болон олон улс, бүс нутгийн стандартын төслийг хэлэлцэн дүгнэлт гаргах, санал өгөх;

9.3.2.энэ хуульд заасан байгууллагын стандартаас бусад стандартчиллын баримт бичгийн төсөлд сонирхогч талуудын санал авах, зөвшилцөх, стандартын төсөл боловсруулах;

9.3.3.шаардлагатай гэж үзвэл тодорхой чиглэлээр техникийн дэд хороог байгуулах талаар санал гаргах;

9.3.4.стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах;

9.3.5.олон улс, бүс нутгийн стандартчиллын байгууллага болон техникийн хороодтой хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

9.3.6.стандартын боловсруулалтын түвшин, агуулга зохих шаардлагад нийцсэн эсэхийг хянах.

9.4.Техникийн хороо, дэд хорооны гишүүд нь ашиг сонирхлоос ангид байна.

10 дугаар зүйл.Стандартыг хэрэглэх, мөрдөх

10.1.Иргэн, хуулийн этгээд хэрэглэх стандартыг сонгоно.

10.2.Иргэн, хуулийн этгээд сонгосон стандартын үзүүлэлт шаардлагыг хангана.

10.3.Хууль тогтоомж, техникийн зохицуулалт, олон улсын гэрээнд эш татсан стандарт нь тухайн баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна.

10.4.Иргэн, хуулийн этгээдийн хооронд байгуулсан гэрээнд талууд стандартыг бүхлээр нь, эсхүл хэсэгчлэн эш татаж хэрэглэхээр тохирсон бол гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

10.5.Гадаадын хөрөнгө оруулалттай, нэг удаагийн шинжтэй томоохон бүтээн байгуулалтад хөрөнгө оруулагч талын стандартыг талууд харилцан тохиролцож, гэрээний нөхцөл болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэглэж болно.

10.6.Энэ хуулийн 10.5-д заасан гадаад улсын стандарт нь хууль тогтоомж, техникийн зохицуулалт, үндэсний стандарт болон Монгол Улсын олон улсын гэрээ,

олон улс, бүс нутгийн стандартаар тогтоосон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах шаардлагыг бууруулсан бол тухайн стандартыг хэрэглэхгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

11 дүгээр зүйл. Техникийн зохицуулалт

11.1. Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор техникийн зохицуулалтыг нийтээр заавал дагаж мөрдөнө.

11.2. Техникийн зохицуулалтыг төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болон энэ хуулийн 11.3-т заасан дүгнэлтийг үндэслэн Засгийн газар батална.

11.3. Техникийн зохицуулалт боловсруулах аргачлалыг стандартаар тогтоох бөгөөд аргачлалын дагуу боловсруулсан эсэхийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хянаж, дүгнэлт гаргана.

11.4. Техникийн зохицуулалтын биелэлтэд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавина.

11.5. Монгол Улсаас гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг батлагдахаас 60-аас доошгүй хоногийн өмнө стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад мэдээлнэ.

11.6. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудаас санал болгож байгаа гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ

12 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний зорилго, хамрах хүрээ

12.1. Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад оршино.

12.2. Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд заавал хамруулна.

12.3.Тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүний жагсаалтыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

12.4.Тохирлын үнэлгээнд заавал хамруулахаас бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгчийн хүсэлтээр хамруулна.

13 дугаар зүйл.Тохирлын баталгаа

13.1.Тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна.

13.2.Нийлүүлэгчийн мэдэгдэлд тавих шаардлагыг стандартаар тогтоож, мэдэгдлийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

13.3.Аюулгүйн тэмдэг, тэдгээрийн хэрэглээнд тавих шаардлагыг стандартаар тогтооно.

13.4.Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээг хүлээн зөвшөөрнө.

13.5.Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсын олон улсын гэрээгээр тохирсон улс орнуудад хүчин төгөлдөр байна.

13.6. Аюулгүйн тэмдгийг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага олгоно.

13.7.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 13.4-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт, тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй.

13.8.Нийлүүлэгчийн мэдэгдэл нь энэ хуулийн 13.5-д заасан тохирлын гэрчилгээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

14 дүгээр зүйл.Тохирлын үнэлгээний байгууллага, түүний эрх, үүрэг

14.1.Тохирлын үнэлгээний байгууллагад лаборатори, техникийн хяналт болон баталгаажуулалтын байгууллага хамаарна.

14.2.Тохирлын үнэлгээний байгууллага нь Монгол Улсын хуулийн этгээд байх бөгөөд холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу үйл ажиллагаа явуулна.

14.3.Тохирлын үнэлгээний байгууллага нь итгэмжлэлд хамрагдаж болно.

14.4.Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага тохирлын үнэлгээ хийнэ.

14.5.Гадаад улсын итгэмжлэлийн байгууллагаас итгэмжлэгдсэн болон гадаад улсын тохирлын үнэлгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тохирлын үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэ хуульд заасан тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллагад бүртгүүлнэ.

14.6.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллагад бүртгүүлээгүй гадаад улсын тохирлын үнэлгээний байгууллагын үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй.

14.7.Тохирлын үнэлгээний байгууллага дараах эрх, үүрэгтэй:

14.7.1.тохирлын үнэлгээний үр дүнг үндэслэн тайлан гаргах, тохирлын гэрчилгээ олгох, хүчингүй болгох, сунгах, түдгэлзүүлэх;

14.7.2.тохирлын үнэлгээг итгэмжлэлээр тогтоосон хүрээнд явуулах;

14.7.3.итгэмжлэлийн шалгуурыг тогтвортой хангах;

14.7.4.тохирлын үнэлгээнд мэргэжлийн хүнийг татан оролцуулах;

14.7.5.тохирлын үнэлгээний дүн, илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх.

14.8.Энэ хуулийн 14.4, 14.5-т заасныг зөрчиж, тохирлын үнэлгээний үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

14.9.Тохирлын үнэлгээний байгууллагын тохирлын үнэлгээний үр дүнгээр тохирлын гэрчилгээг хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

14.10.Зөвшөөрөл эзэмшигч энэ хуульд заасан стандарт, техникийн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл болно.

15 дугаар зүйл.Баталгаажуулалтын байгууллага

15.1.Баталгаажуулалтын байгууллага нь бүтээгдэхүүний, менежментийн тогтолцооны, ажилтны гэсэн төрөлтэй байна.

15.2.Баталгаажуулалтын байгууллага нь тохирлын үнэлгээг схемийн дагуу гүйцэтгэнэ.

15.3.Баталгаажуулалтын байгууллага нь энэ хуулийн 15.2-т заасан схемийг ISO/IEC17067 стандартын дагуу боловсруулж батална.

15.4.Баталгаажуулалтын шинжээчид эрх олгоход тавигдах нийтлэг шаардлагыг стандартаар тогтооно.

15.5.Баталгаажуулалтын үйл ажиллагааг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх авсан баталгаажуулалтын шинжээч гүйцэтгэнэ.

15.6.Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлэгдсэн лаборатори, техникийн хяналтын байгууллагын үр дүнг ашиглана.

16 дугаар зүйл.Лаборатори

16.1.Лабораторийг үйл ажиллагааны чиглэл, техник тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадамжаар нь дараах шатлалаар ангилна:

16.1.1.хяналтын лаборатори;

16.1.2.баталгаажуулалтын лаборатори;

16.1.3.лавлагаа лаборатори.

16.2.Хяналтын лаборатори нь орон нутагт үйл ажиллагаа явуулж, баталгаажуулалтын лаборатори болон лавлагаа лаборатортой шинжилгээний арга аргачлалыг хөгжүүлэх, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, лабораторийн шинжилгээний үр дүнгийн мэдээллийн сан бүрдүүлэх асуудлаар хамтран ажиллана.

16.3.Баталгаажуулалтын лаборатори нь бүсийн төвүүдэд үйл ажиллагаа явуулж, тухайн бүс нутагт ажиллаж байгаа хяналтын лабораториудын үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжиж ажиллана.

16.4.Лавлагаа лаборатори нь дэвшилтэд технологийг хэрэглэж хяналтын лаборатори, баталгаажуулалтын лабораторийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйгээр хангаж, шинжилгээтэй холбогдсон маргааныг магадлан шинжилж, шинжилгээний үр дүнгийн эцсийн шийдвэрийг гаргана.

16.5.Лавлагаа лаборатори нь зохион байгуулалт, санхүү, төсвийн хувьд бие даасан хараат бусаар үйл ажиллагаа явуулна.

16.6.Лавлагаа лаборатори нь шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, дүн шинжилгээ хийж, төрийн бодлого, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ.

16.7.Лабораторийн үйл ажиллагаа дараах төрөлтэй байна:

16.7.1.хүнсний аюулгүй байдлын;

16.7.2.хүрээлэн буй орчны;

16.7.3.эм, эмнэлгийн хэрэгслийн;

16.7.4.барилгын материалын;

16.7.5.ашигт малтмалын;

16.7.6.хуульд заасан бусад.

16.8.Лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлтийг зохион байгуулах, салбар хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор лабораторийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний дэргэд лабораторийн бодлогын орон тооны бус зөвлөл ажиллана.

16.9.Лабораторийн бодлогын зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.9.1.лабораторийн шинжилгээний техник, тоног төхөөрөмж, урвалж бодис, программ хангамжийг уялдуулан зохицуулах;

16.9.2.лабораторийг чадавхжуулах зорилгоор хүний нөөцийн менежмент, сургалтыг эрх бүхий байгууллагатай зөвшилцөн зохион байгуулах;

16.9.3.лабораторийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тухай мэдээллийг судлан боловсруулж, тэдгээрийн давхардал, хийдлийг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх.

16.10.Лабораторийн бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

16.11.Лабораторийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

17 дугаар зүйл.Техникийн хяналтын байгууллага

17.1.Техникийн хяналт нь үйлдвэрлэгчийн, импортлогчийн, хөндлөнгийн гэсэн төрөлтэй байна.

17.2.Техникийн хяналтын байгууллага нь бүтээгдэхүүн, түүний зохион бүтээлт, үйлдвэрлэл, ажил үйлчилгээ, ажлын байрны орчин нөхцөл, хэвийн ажиллагаа, аюулгүй байдлын үзүүлэлт нь стандартаар тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛ

18 дугаар зүйл.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго, чиг үүрэг

18.1.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн зорилго нь худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах, худалдааг хөнгөвчлөх, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг, гадаад улс болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

18.2.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллага нь тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, итгэмжлэлийн ажил, үйлчилгээний үнэ тариф тогтоох, тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэх, итгэмжлэлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, итгэмжлэлийн дараах хяналт хэрэгжүүлэх, итгэмжлэлийн шинжээчийг сургах, сонгон шалгаруулах, эрх олгох, итгэмжлэлийн бүртгэл, мэдээллийн сан хөтлөх, итгэмжлэлийн үр дүнг үндэсний болон олон улсын хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

19 дүгээр зүйл.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт

19.1.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тогтолцоо нь итгэмжлэлийн Удирдах зөвлөл (цаашид "Удирдах зөвлөл" гэх), итгэмжлэлийн байгууллага, техникийн хороо, маргаан шийдвэрлэх комисс, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага, итгэмжлэлийн шинжээчээс бүрдэнэ.

20 дугаар зүйл.Удирдах зөвлөл

20.1.Үндэсний итгэмжлэлийн байгууллагын үйл ажиллагааны хараат бус, мэргэжлийн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байдлыг хангах чиг үүрэг бүхий Удирдах зөвлөл ажиллана. Удирдах зөвлөл нь Үндэсний итгэмжлэлийн байгууллагын дарга болон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.

20.1.1. Үндэсний итгэмжлэлийн байгууллагын даргыг итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

20.1.2.Удирдах зөвлөлийн орон тооны бус гишүүн нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, итгэмжлэл, эрх зүй, эдийн засаг, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шинжлэх ухаан, техникийн чиглэлээр таван жилээс доошгүй хугацаанд ажилласан туршлагатай, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай, ашиг сонирхлын зөрчилгүй байна.

20.1.3.Удирдах зөвлөлийн орон тооны бус гишүүдийг төрийн байгууллага, мэргэжлийн холбоо, шинжлэх ухааны байгууллага, хэрэглэгч болон хувийн хэвшлийн төлөөллийн тэнцвэртэй оролцоог ханган, нээлттэй нэр дэвшүүлэлт, сонгон шалгаруулалтын үндсэн дээр итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гурван жилийн хугацаагаар томилно. Бүрэн эрхийн хугацааг нэг удаа сунгаж болно.

20.1.4.Удирдах зөвлөлийн гишүүн хэлэлцэх асуудалтай холбоотой шууд болон шууд бус ашиг сонирхолтой бол энэ тухайгаа урьдчилан мэдэгдэж, тухайн асуудлыг хэлэлцэх, санал өгөх, шийдвэр гаргахад оролцохгүй.

20.1.5.Удирдах зөвлөлийн орон тооны бус гишүүнийг өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан, энэ хуульд заасан шаардлагыг хангаах больсон, ашиг сонирхлын зөрчил үүссэн, бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл хуульд заасан бусад үндэслэл бий болсон тохиолдолд томилсон эрх бүхий этгээд чөлөөлнө.

20.1.6.Удирдах зөвлөлийн ажиллах журмыг итгэмжлэлийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

20.2.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллага нь итгэмжлэлийн ажил, үйлчилгээний хураамж, сургалт, лавлагаа, бүртгэл, мэдээллийн үйлчилгээний төлбөр, олон улсын байгууллага, хандивлагч орны хандив, тусламж болон хуульд заасан бусад өөрийн орлогоор санхүүжнэ.

20.3.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

21 дүгээр зүйл.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллага

21.1.Итгэмжлэлийн байгууллага итгэмжлэлийн бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд дараах бүрэн эрхтэй:

21.1.1.тохирлын үнэлгээний итгэмжлэлийн байгууллагын чадавхыг тогтоох, итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

21.1.2.итгэмжлэлийн шинжээчид тавих шаардлагыг тогтоох, шинжээч сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох, цуцлах;

21.1.3.итгэмжлэлийн лавлагаа, мэдээллийн улсын нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх;

21.1.4.мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт явуулах;

21.1.5.олон улс, бүс нутгийн байгууллага, гадаад улстай итгэмжлэлийн үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх, хэлэлцээрт нэгдэх, олон улсын байгууллагад гишүүнээр элсэх санал гаргах;

21.1.6.олон улс, бүс нутаг, гадаад улсын итгэмжлэлийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

21.1.7.итгэмжлэлийн байгууллагыг гадаад, дотоодод байгууллагын дарга төлөөлөх;

21.1.8.хараат бус бие даасан олон улсын зарчмыг удирдлага болгоно;

22 дугаар зүйл.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн техникийн хороо

22.1.Техникийн хороо нь тохирлын үнэлгээний итгэмжлэлийн шаардлага, шалгуурыг хангасан эсэхэд техникийн дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

22.2.Техникийн хороо нь орон тооны бус байх бөгөөд сонирхогч талуудын оролцоог тэгш хангасан байна.

23 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх комисс

23.1.Тохирлын үнэлгээний байгууллагаас итгэмжлэлийн талаар гаргасан маргааныг Маргаан шийдвэрлэх комисс (цаашид " Комисс " гэх шийдвэрлэнэ.

23.2.Удирдах Зөвлөл нь итгэмжлэлийн шийдвэртэй холбоотой маргаан үүссэн тохиолдол бүрд сонирхлын зөрчлөөс ангид, мэргэшсэн шинжээчдээс бүрдсэн Комиссыг байгуулж, ажиллуулна.

24 дүгээр зүйл.Итгэмжлэлийн шинжээч

24.1.Итгэмжлэлийн шинжээч нь тохирлын үнэлгээний байгууллагын чадавхыг стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

24.2.Шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна:

24.2.1.итгэмжлэлийн байгууллагаас олгосон эрхтэй байх;

24.2.2.мэргэжлийн ур чадвар, туршлагатай байх;

24.2.3.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

24.3.Шинжээчийн чадавхыг тогтмол үнэлж, сургалт, дахин баталгаажуулалтад хамруулна.

24.4.Шинжээчийн тайлан нь итгэмжлэлийн шийдвэр гаргах үндсэн нотолгоо болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА

25 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо

25.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо нь стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний харьяа аймаг, нийслэл дэх байгууллагаас бүрдэнэ.

25.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ энэ хуулийн биелэлтийг хангаж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

25.3.Хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, улсын байцаагч, албан тушаалтан нь хариуцсан чиглэлээр стандартчилал, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

26 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх Засгийн газрын бүрэн эрх

26.1. Засгийн газар стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1. стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх бодлого, хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

26.1.2. энэ хуулийн 11.2-т заасны дагуу техникийн зохицуулалтыг батлах;

26.1.3. энэ хуулийн 14.4-т заасан хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний жагсаалтыг батлах, хэрэгжилтийг хангуулах;

26.1.4. энэ хуульд заасан төрийн байгууллагын төлбөртэй ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг тогтоох;

26.1.5. энэ хуульд заасан Стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах журмыг батлах.

27 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

27.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1. салбарын хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

27.1.2. стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн талаарх бодлогын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

27.1.3. чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, алдаршуулах зорилгоор үндэсний чанарын шагнал олгох;

27.1.4. стандартчиллын ажлын төлөвлөгөө, биелэлт, шинжлэх ухаан, техникийн түвшний үзлэг үр дүн, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах.

27.1.5. энэ хуульд заасан төрийн байгууллагын төлбөртэй ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг чөлөөт зах зээлийн үнэ тарифтай уялдуулан батлуулах;

28 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалтын талаарх төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

28.1.Төрийн захиргааны төв байгууллага нь эрхэлсэн асуудлын хүрээнд стандартчилал, техникийн зохицуулалтын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

28.1.1.салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, хяналт шалгалт явуулах;

28.1.2.стандартыг шинэчлэн сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

28.1.3.хариуцсан асуудлаар энэ хуульд заасан Техникийн хороонд гишүүнийг ажиллуулах;

28.1.4.салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөх стандарт, техникийн зохицуулалтын талаар нийтэд мэдээлэх, сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

28.1.5.эрхэлсэн асуудлаар стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах;

28.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стандартчилал, техникийн зохицуулалтын талаар мэдлэг олгох агуулгыг дээд, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт тусгана.

29 дүгээр зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

29.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний харьяа аймаг, нийслэл дэх байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

29.1.1.эрхэлсэн асуудлын хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

29.1.2.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний үйл ажиллагаанд баримтлах баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;

29.1.3.стандартчиллын техникийн хороо байгуулах, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааг зохицуулах;

29.1.4.стандартчиллын техникийн хорооны саналыг үндэслэн дэд хороог байгуулах, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааг зохицуулах;

29.1.5.Стандартчиллын техникийн хорооны дүгнэлтийг үндэслэн үндэсний стандартыг батлах, хүчингүй болгох, улсын бүртгэлийн дугаар олгох, бүртгэх, албан ёсны эхийг хадгалах, олон нийтэд мэдээлэх;

29.1.6.тохирлын үнэлгээг энэ хуульд заасны дагуу явуулах;

29.1.7.хариуцсан асуудлаар олон улсын байгууллагад гишүүнээр элсэх санал гаргах, олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

29.1.8.хариуцсан асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах;

29.1.9.энэ хуульд заасан мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах, удирдах, хяналт тавих;

29.1.10.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний онолын суурь судалгаа хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

29.1.11.энэ хуулийн 29.1.10-т заасан ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

29.1.12.чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг алдаршуулан үндэсний чанарын шагнал олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

29.1.13.стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээг хэрэгжүүлэх талаар холбогдох төрийн болон бусад байгууллагад зөвлөмж өгөх, хамтын ажиллагааг зохион байгуулах;

29.1.14.тохирлын үнэлгээний тогтолцооны үр нөлөө, үр ашигт дүн шинжилгээ хийж, санал боловсруулах, хэрэгжүүлэх;

29.1.15.үндэсний болон олон улсын стандартын үйл явцын мэдээллийг тухай бүр олон нийтэд нээлттэй хүргэх;

29.1.16.олон улс, бүс нутаг, гадаад орны стандартчиллын байгууллагаас хүчингүйд тооцсон, шинэчлэгдсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан үндэсний болгосон стандартын мэдээллийг төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллагуудад тогтмол хүргэх;

29.1.17.үндэсний болгон баталсан олон улс, бүс нутаг, гадаад орны стандартчиллын байгууллагын стандарт хүчингүй болсон тохиолдолд тухайн стандартыг Стандартчиллын техникийн хороогоор хэлэлцэж хүчингүй болгох.

29.2.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

29.3.Аймаг, нийслэл дэх Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

29.4.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн стандартчиллын ажлын төлөвлөгөө, биелэлт, шинжлэх ухаан, техникийн түвшний үзлэгийн үр дүн болон стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дүнд хийсэн дүгнэлтийг жил бүр Засгийн газарт танилцуулна.

29.5.Стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон холбогдох бусад байгууллагад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна.

30 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний салбар дундын зохицуулалт

30.1.Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нь стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулна.

30.2.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбар дундын уялдааг хангах зорилгоор төрийн захиргааны төв байгууллагатай хамтран дараах үйл ажиллагаа явуулна:

30.2.1.стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;

30.2.2.стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх;

30.2.3.стандартыг шинэчлэн сайжруулах зорилгоор таван жил хүртэлх хугацаанд шинжлэх ухаан, техникийн түвшинд үзлэг хийх;

30.2.4.стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн талаарх судалгаа, тайлан мэдээг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан эрх бүхий байгууллагаас жил бүр гаргуулах;

30.2.5.энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах.

30.3.Энэ хуульд заасан тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхдээ тохирлын баталгаатай эсэхэд гаалийн байгууллага хяналт, шалгалт хийнэ.

30.4.Тохирлын баталгаатайгаар улсын хилээр нэвтрүүлсэн бараа, бүтээгдэхүүний статистик мэдээллийг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хагас жил тутам ирүүлнэ.

30.5.Эрх бүхий этгээд тохирлын гэрчилгээг үндэслэн зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулж болно.

30.6.Төрийн захиргааны төв байгууллага нь тухайн салбарт мөрдөгдөж байгаа шинжлэх ухаан, техникийн түвшний үзлэгийг үндэслэн шаардлагатай стандартыг шинэчилнэ.

30.7.Стандарт, техникийн зохицуулалт боловсруулах, шинэчлэхэд шаардагдах зардлыг төсвийн байгууллага жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлнэ.

31 дүгээр зүйл.Стандартын хяналт

31.1.Бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлснээс хойшхи үе шатанд стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн хяналтыг улсын байцаагч хэрэгжүүлнэ.

31.2.Улсын байцаагч нь хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүн болон бусад хуулиар хэрэгжүүлэхээр заасан бүтээгдэхүүний тохирлын баталгаатай эсэхэд хяналт тавина.

31.3.Эрх бүхий улсын байцаагч нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын үр дүнг ашиглаж болно.

31.4.Энэ зүйлийн 31.1-д заасан хяналтыг хэрэгжүүлэх улсын байцаагч нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

31.5.Энэ хуулийн 14.3-т заасан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн байгууллага дараах шаардлагыг хангаж ажиллана.

31.5.1.хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартчиллын баримт бичигт заасан шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх;

31.5.2.харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн дагуу экспортлогч орны итгэмжлэгдсэн байгууллагын хүчин төгөлдөр тохирлын гэрчилгээ, нийлүүлэгчийн мэдэгдэл, түүнтэй адилтгах үр дүн бүхий бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх;

31.5.3.тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүнээс бусад бүтээгдэхүүнийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх;

31.5.4.хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 31.5.2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр тэмдэг, гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхэд тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй байх;

31.6.Хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, улсын байцаагч, албан тушаалтан нь хариуцсан чиглэлээр стандартчилал, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

31.7.Стандартчилал, техникийн зохицуулалтын хяналтын тайланг хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь хяналтын тайланг энэ хуулийн 29.1-д заасан байгууллагад жил бүр хүргүүлнэ.

32 дугаар зүйл.Иргэн, хуулийн этгээдийн эрх үүрэг

32.1.Иргэн, хуулийн этгээд нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар дараах эрхтэй:

32.1.1.бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлээр стандарт, менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, тохирлын үнэлгээнд хамрагдах;

32.1.2.стандарт санаачлах;

32.1.3.стандарт боловсруулах үйл ажиллагааны үндсэн баримт бичигт нийцүүлэн стандарт боловсруулах;

32.1.4.стандарт, стандартчиллын хөтөлбөрийн төсөлд санал өгөх.

32.2. Иргэн, хуулийн этгээд нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар дараах үүрэгтэй:

32.2.1.стандарт, техникийн зохицуулалтаар тогтоосон шаардлагын дагуу бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;

32.2.2.стандартыг боловсруулах, бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах, түүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх;

32.2.3.стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний чиглэлээр ажилтныг чадавхжуулах;

32.2.4.хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын баталгаатайгаар Монгол Улсын зах зээлд нийлүүлэх;

32.2.5.тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээтэй бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх;

32.2.6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээ нь тухайн бүтээгдэхүүний техникийн зохицуулалт болон тогтоосон шаардлагад нийцсэн байна.

32.2.7.хуульд заасан бусад.

32.3.Иргэн, хуулийн этгээд, сонирхогч талуудын боловсруулсан стандартын төсөл нь хууль тогтоомж, техникийн зохицуулалт болон үйлдвэрлэгч, хэрэглэгчийн эрх ашигт харшлаагүй, нийтийн ашиг сонирхол, хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахааргүй байна.

32.4.Иргэн, хуулийн этгээд нь бүтээгдэхүүн, үйлчилгээнд стандарт, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлээгүй талаар гомдол, мэдээллийг Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад гаргах бөгөөд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу мөнгөн урамшуулал олгож болно.

32.5.Энэ хуулийн 32.4-т заасан урамшуулал олгох асуудлыг Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлэх асуудлыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

ДОЛДУГААР БҮЛЭГ СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

33 дугаар зүйл.Мэдээллийн нэгдсэн сан

33.1.Стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн нэгдсэн мэдээллийн сан (цаашид “Мэдээллийн нэгдсэн сан” гэх) тай байна.

33.2.Мэдээллийн нэгдсэн сан дараах төрөлтэй байна:

33.2.1.стандартчиллын баримт бичгийн мэдээллийн сан;

33.2.2.итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын мэдээллийн сан;

33.2.3.баталгаажуулалтын үр дүнгийн мэдээллийн сан;

33.2.4.лабораторийн шинжилгээний үр дүнгийн мэдээллийн сан;

33.2.5.техникийн хяналтын үр дүнгийн мэдээллийн сан;

33.2.6.сорьц тогтоолгон баталгаажсан үнэт металлаар хийсэн бүтээгдэхүүний болон гэрчилгээтэй эрдэнийн чулууны мэдээллийн сан;

33.2.7.баталгаажуулалтын шинжээчийн мэдээллийн сан;

33.2.8.стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийн хяналтын мэдээллийн сан;

33.2.9.энэ хуулийн хүрээнд хамаарах бусад.

33.3.Мэдээллийн нэгдсэн сан нь нэгдсэн удирдлага зохицуулалт бүхий программ хангамжтай байна.

33.4.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн нэгдсэн санг удирдах, хөгжүүлэх, нууцлал, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангана.

33.5.Стандартчилал, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмыг Засгийн газар батална.

34 дүгээр зүйл.Мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт, хөгжүүлэлт

34.1.Энэ хуулийн 33.2-т заасан мэдээллийн нэгдсэн санг дараах байгууллагууд бүрдүүлнэ:

34.1.1.стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

34.1.2.итгэмжлэлийн байгууллага;

34.1.3.хяналт хэрэгжүүлэх байгууллага;

34.1.4.гаалийн байгууллага;

34.1.5.тохирлын үнэлгээний байгууллага;

34.1.6.бусад.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан байгууллагууд мэдээллийг тухай бүр мэдээллийн нэгдсэн санд оруулна.

34.3.Мэдээллийн нэгдсэн сан нь эрх бүхий байгууллагууд мэдээлэл оруулах, солилцох, хянах нөхцөлийг бүрдүүлж, ашиглах боломжтой байна.

34.4.Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл бүртгэх, баяжуулах, баталгаажуулах чиг үүргийг энэ зүйлийн 34.1-д заасан байгууллага мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

35 дугаар зүйл.Мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт

35.1.Мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл нь нээлттэй, хаалттай гэсэн төрөлтэй байх бөгөөд мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллээс төрийн болон албаны, хувь хүн, хуулийн этгээдийн нууцад хамаарах болон олон улсын гэрээ хэлэлцээрт нууцлахаар зааснаас бусад мэдээлэл нь нийтэд нээлттэй байна.

35.2.Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах хүрээнд стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шаардлагатай программ хангамж, техник хэрэгслээр хангагдсан байна.

35.3.Мэдээллийн нэгдсэн сан үрэгдэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд мэдээллийн санг нөөцлөн цахим технологийн дагуу Архивын тухай хууль тогтоомжид заасан хугацаанд хадгална.

35.4.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл бодит бус байгаа нь баримтаар тогтоогдвол энэ хуулийн 34.1-д заасан байгууллага залруулгыг хийнэ.

35.5.Мэдээллийн нэгдсэн сан хариуцсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан мэдээллийн санг бусад этгээдэд шилжүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгоор ашиглахыг хориглоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ

36 дугаар зүйл.Санхүүжилт

36.1.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний харьяа аймаг, нийслэлийн байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зардал, олон улсын байгууллагын гишүүний татварыг улсын төсвөөс, энэ хуульд заасан стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар онолын суурь судалгаа хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зардлыг Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангаас тус тус санхүүжүүлнэ.

36.2.Стандартчилал, тохирлын үнэлгээний үйл ажиллагаа, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг стандартад нийцүүлэн шинэчлэх зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

36.3.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн санхүүжилт нь энэ зүйлийн 36.1-д зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

36.3.1.төлбөртэй ажил, үйлчилгээний хураамж;

36.3.2.олон улсын байгууллага, хандивлагч орны хандив, тусламж.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА

37 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

37.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчил, гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

37.2.Энэ хуулийг зөрчсөн нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

38 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

38.1.Энэ хуулийг 2027 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг